

Дафа-гийн бясалгал бол нарийн чанд

Бясалгалын хүрээнд “Анх эхэлж бясалгаж байсан шигээ урам зоригтой бясалга, тэгвэл амжилтад хүрэх нь дамжиггүй” гэсэн үнэн үг байдаг. Дафа нийтийн дунд түгэн дэлгэрснээр тэнгэрийн олон нууцыг илчилсэн. Энэ нь дэлхийн хүмүүсийг, бясалгалын хүрээг, тэр байтугай Бурхдуудын орныг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр цочроосон. Хувь тавилангийн холбоотой болон хувь тавилангүй хүмүүс Дафа-г олж авч, бясалгахаар ар араасаа орж ирцгээсэн. Зарим хүн анх бясалгахдаа маш тууштай сэтгэлээр эхэлж бясалгадаг. Гэхдээ зарим хүний хувьд удаан хугацаанд бий болсон янз бүрийн зууралдлаасаа бясалгалын явцдаа ч салахад хэцүү байдаг, яваандаа ийм хүмүүсийн идэвх нь сулардаг; үүний зэрэгцээ тэд ажилдаа завгүй, мөн гэр орныхоо ахуй амьдралыг сайн зохицуулж чаддаггүй, Фа сурах, дасгалаа хийх цаг зав бүр ч гаргадаггүй; хэдийгээр тэд хааяа зарим нийтийн үйл ажиллагаанд оролцдог ч хичээнгүй байж чаддаггүй. Цаг хугацаа өнгөрөх тусам тэд бясалгагч шиг байхаа бүр больж, бясалгагч хүний хийх ёсгүй зүйлсийг хүртэл хийдэг болсон, энэ байдал үргэлжилбэл маш аюултай байх болно!

Анх Фа цэвэрлэгээний үеийн Дафа-гийн шавь нарын эгнээнд ороход хүн бүрийн мэддэг тал нь Бурхдад андгай тангараг өргөж амиараа батлан гэрээнд гарын үсэг зурсан, Дафа-гийн шавь нарын хийх ёстой түүхэн үйл хэргээ биелүүлэхээ амласан, тэр мөчөөс хойш энэ амь бодь Гурамсан Ертөнцийн хамааралд оршихоо больсон. Иймээс Багш Дафа-гийн шавь нарын нэрсийг Гурамсан ертөнцөөс, Хүний ертөнцөөс, Эрлэгийн орноос, тэр байтугай Тамаас хассан. Үүнээс хойш Дафа-гийн шавийн амийг зөвхөн Дафа хариуцах бөгөөд тэд хойд төрөл олох тойргоор явахаа болино, тэд гэм нүгэлтэй байсан ч Тамын эрхшээлд орохгүй. Сайн бясалгасан нэг нь Төгс гэгээрэлд хүрч шинэ орчлон ертөнц дэхь өөрийн оршихуйдаа буцаж Тэнгэрлэг хаант орноо хариуцах болно. Бясалгалдаа бүтэлгүйтсэн, тангаргаа зөрчсөн, Дафа-гийн эсрэг гэмт хэрэг үйлдэгсэд нь өөрийн амиараа өргөсөн тангаргийнхаа дагуу зохих үр дагавраа хүлээх болно! Багш нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс тэдэнд үргэлж боломж олгож байсан. Гэвч тэд хэрхэн талархахаа мэддэггүй төдийгүй зууралдсан сэтгэлээсээ салдаггүй хэвээр байдаг.

Хэдийгээр Дафа-гийн шавь нарын бясалгалын хэлбэр чөлөөтэй боловч бясалгагчдад тавигдах шаардлага хатуу, тэдний түүхэн үүрэг даалгавар нь нарийн чанд бөгөөд асар их ач холбогдолтой. Учир нь Дафа-гийн шавь Гэгээрлийн хутагт хүрснийхээ дараа онцгой амь бодь болох тул Орчлон ертөнцийн бүх Бурхдын нүдэнд Фа-цэвэрлэгээний үед хатуужсан ер бусын агуу Гэгээрэгч юм. Хуучин хүчнүүд яагаад Дафа-гийн шавь нарт ийм хатуу ширүүн ханддаг вэ? Энэ нь нэг талаар та нарт атаархсанаас, нөгөөтэйгөөр тэд хэт олон, маш хүчтэй зууралдсан сэтгэлтэй, янз бүрийн тохиолдолд Фа-гийн байр сууринаас ханддаггүй, асуудалд энгийн хүний байдлаар ханддаг зарим Дафа-гийн сурагчдыг дорд

үздэг. Тийм учраас сайн хийдэггүй хүмүүсийн зовлон зүдүүр илүү ширүүн байдаг, хэрэв энэ байдал удаанаар үргэлжилбэл маш аюултай!

Фа-цэвэрлэгээ хэдийнээ төгсгөлийн үедээ ирсэн байна, Хуучин хүчнүүд удаан хугацааны турш жинхэнэ бясалгаж чадаагүй, эсвэл тангаргаа зөрчсөн, түүхэн даалгавраа биелүүлэхгүй байгаа хэсэг хүмүүсийг устгах гэж байна. Тиймээс тэд чөтгөрүүдийг ашиглан, тэдгээрийг Дафа-гийн сурагчдын дунд орсон хамгийн муу хүмүүсийн биед оруулж тэдний хүний бодол, зууралдсан сэтгэл, дургүйцэл, үзэн ядалт болон бусад муу санааг ашиглан удаан хугацаанд Фа-г дагадаггүй, жинхэнэ бясалгадаггүй сурагчдыг өдөөн хатгадаг. Энэ нь Дафа-гийн сурагчдын орчныг эвдэх гэсэн оролдлого мэт харагдавч үнэн хэрэгтээ хуучин хүчнүүд Дафа-гийн сурагчдын нийт бүрэлдэхүүнийг шигшихийн тулд тийм хүмүүсийг ашигладаг, тэд Дафа-гийн сурагчдын дунд хагарал гаргадаг, бясалгахдаа олон зууралдсан сэтгэлээсээ салж чаддаггүй, удаан хугацаанд Фа зарчмаа дагахгүй байгаа, цааш бясалгаж болохгүй болсон хүмүүсийг илчлэхийг хүсдэг. Энэ эгзэгтэй мөчид, тэдгээр хүмүүсийг дэмждэг, дагадаг хүмүүсийг илрүүлж арчих зорилготой юм. Одоо хуучин хүчнийхэн ийм хутган үймүүлэгчдийг ашиглаж байгаагийн жинхэнэ учир нь энэ юм.

Асуудал тарьж байдаг хүмүүсийг чөтгөр удирдаж байдаг ч тэд өөрсдөө үүнийг мэддэггүй, тэд үүнийг хүлээн зөвшөөрөхгүй нь мэдээж. Сэтгэлийнхээ гүнд зууралдсан сэтгэл, дургүйцэл тээж явдаг хүмүүс үнэхээр байдаг, тэд Дафа болон бясалгалын нарийн байдлыг үл тоомсорлон тэдэнд боломж олгодог, өөгшүүлдэг, тэднийг хүлээн зөвшөөрдөг, сонсдог, үздэгт гол асуудал нь байгаа юм. Дафа бол Тэнгэрийн Хууль, хэн ч үүнийг эмх замбараагүйтүүлж чадахгүй! Эмх замбараагүйтэж байгаа нь хүний сэтгэл юм! Өөрсдийгөө ингэж харуулж байгаа хүмүүс бол яг хуучин хүчнийхний устгахыг хүсдэг хүмүүс юм. Удаан хугацаагаар Фа-гаас хазайсан хүмүүс онцгой анхаарах хэрэгтэй. Тэдгээр зууралдсан сэтгэлтэй, гомдол үзэн ядах сэтгэлтэй, тэр тусмаа хийсэн алдааныхаа улмаас Дафа-гийн хүн аврах төслөөс хасагдсан буюу сэтгэлдээ дургүйцэл тээж явдаг хүмүүс, тэдгээр үймээн гаргагчидтай хамгийн их санал нийлдэг. Тэд хамтдаа цугларан дургүйцлээ илэрхийлэх үед тэдний хүний сэтгэл нь хамгийн ихээр илэрдэг. Тийм хүмүүс хэзээ ч манай заасны дагуу, Фа дагуу асуудлыг цэгнэдэггүй, тэд өөрсдөөсөө: Ийм дургүйцэх сэтгэлтэй байх нь зөв үү буруу юу? Бясаллагч хүнд ийм сэтгэл байж болох уу? Фа-д нийцэж байна уу үгүй юу? гэж асуудгүйг бид харж болно. Чи сайн бясалгахгүй бол энэ нь хувийн асуудал, харин түүний үйлдэл бидний бясалгалд ноцтой хохирол учруулж хүн аврах үйл хэрэгт сөргөөр нөлөөлбөл, энэ бол ноцтой асуудал. Бүх амь бодиудыг аврах зорилгоор Бүтээгчийн бусад олон Бурхдын хамт олон сая, сая жилийн туршид төлөвлөсөн "Фа-цэвэрлэгээ" агуу үйл хэрэгт хүмүүсийг саад учруулахыг яаж зөвшөөрөх юм?! Энэ бол аль ч давхаргын амь бодиудын огт хийж болохгүй хамгийн том нүгэл!

Бясалгахаа аль эртнээс больсон гэж ярьж явдаг хүмүүс бас байдаг, тэд өөрсдийгөө гаднын хүмүүс гэж үздэг, тиймээс Дафа-г гутаасан зүйл хэлсэн ч, хийсэн ч болно гэж боддог. Би тэдгээр хүмүүст хэлье: Хэрэв та нар урьд Дафа-д орж чадсан бол аль хэдийн амь насаараа

тангараглаж гэрээ байгуулсан гэсэн үг. Чиний хэдэн настай байх нь, хэр олон жил өнгөрсөн нь хамаагүй, тангараг бол нарийн чанд. Өөрөөр хэлбэл, чи бясалгахаа больсон гэж хэлж байна, гэвч Дафа-гаас эрт орой гарснаас, бясалгаж байгаа үгүй эсэхээс үл хамааран чи тангаргаа заавал биелүүлэх ёстой. Чиний анх орчлон ертөнцийн Дафа-гийн Фа-цэвэрлэгээний үеийн шавь болохыг хүссэн тэр цаг мөч бол маш, маш нарийн чанд байдаг. Энэ нь аливаа амь бодийн хувьд маш чухал сонголт юм, тэгэх тусмаа чи амь насаараа тангараг өргөж гэрээнд гарын үсэг зурсан! Хүсвэл бясалгана, хүсэхгүй бол бясалгахгүй гэж хэлэхийг чи энгийн асуудал гэж бодож байна уу? Хүн төрөлхтөнд, Сансар огторгуйн энэхүү хүнд үүрэг хариуцлага, Бурхад, Бүтээгчээр тоглоом хийхийг яаж зөвшөөрөх билээ! Гэрээнд нэгэнт гарын үсэг зурсан бол үүнийг заавал биелүүлэх ёстой!

Нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс би тэдгээр хүмүүст энэ Фа-г дахин, сүүлчийн удаа зааж байна. Аль замаар явах хүсэлтэйгээ өөрсдөө шийд! Хуучин хүч биднийг дарахын тулд харгис ХКН-аар удирдуулсан энэ том гүрний бүх хүчийг дайчилж байгаа нь та нарын бясалгал ямар нарийн чанд болохыг ойлгохгүй байна гэж үү? Түүхэнд хүн хэзээ ч Бурхан болж байгаагүй. Тэгвэл энэ нь яаж нарийн чанд байхгүй байх билээ? Дафа-гийн шавь нарын бясалгалын явцад, сайн хийж чадаагүйгээс тулгарч байсан янз бүрийн гашуун сургамжууд чамайг сэрээхэд хангалтгүй байна гэж үү?

Багш Ли Хонжи

2023 оны 9 сарын 1